

**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 04 дүгээр сарын
27-ны өдөр

№ ХЭХ 03/01

Улаанбаатар
хот

**“Жуулчин Дюти фрий” ХК-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
тэмдэглэл.**

2022 оны 04 сарын 27-ны өдөр 10:00 минут, Лхагва гараг, Хан-Уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Таван Богд Группийн төв байрны, 2,5 дугаар давхрын хурлын танхимд хуралдав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Сайн байцгаана уу. Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн амар амгаланг эрье. Ингээд хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн 2022 оны 04 сарын 27-ны өдрийн хурдын дэгийг та бүхэнд танилцуулъя. Хурлаар хэлэлцэх асуудал.

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах /Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр/
2. ТУЗ-өөс санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хэлэлцэх, батлах, /Ерөнхий нягтлан бодогч Б.Алтанцэцэг/
3. Компанийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг танилцуулах /Ерөнхий нягтлан бодогч Б.Алтанцэцэг/
4. Компанийн 2021 оны ноогдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ/
5. Компанийн 2022 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг танилцуулах, батлах /Ерөнхий нягтлан бодогч Б.Алтанцэцэг/

Дараагийн хэлэлцэх асуудал нь асуулт хариулт байна. Хурлаас гарсан шийдвэр тогтоолыг танилцуулах, батлуулах. Хурлыг энэ дэс дарааллын дагуу явуулах юм байна.

Хурлын дэгийг танилцуулж дуусав.

Одоо хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу хурлын ирц бүртгэлийн талаар тооллогын комиссын гишүүн Ж.Түвшинтуул танилцуулна.

Тооллогын комиссын гишүүн Ж.Түвшинтуул: Сайн байцгаана уу. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн танилцуулъя.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит энэ хуралд 10 хувьцаа эзэмшигч биеэр оролцож, нийт саналын эрх бүхий нийт хувьцааны 78,52 хувь болж байгааг хуралд оролцож байгаа

хувьцаа эзэмшигч нар болон хурлын даргад мэдээлсүгэй. Ингэснээр хурлыг хүчин төгөлдөрт тооцож хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг үргэлжлүүлэхэд ирц хүрсэн байна.

Хурлын ирцийн тогтоолыг танилцуулав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хурлын ирц хүчин төгөлдөр болсон байна. Тооллогын комиссоос тогтоол гарсантай та бүхэн танилцлаа.

Хурлын дэгийн дагуу компанийн үйл ажиллагааг танилцуулаад хурлаа эхэлье.

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр: Сайн байцгаана уу та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. 2021 оны үйл ажиллагааны тайланг танилцуулъя. Асууж тодруулах зүйл байвал шууд шууд асуугаад явах боломжтой.

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах /Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр/ танилцуулав.

Компанийн эрхэм зорилго бол зах зээлд чанарын шаардлага хангасан өндөр чанартай үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж салбартаа манлайлах гэсэн зорилготой. МУ-ын хэмжээнд ойролцоогоор 14 татваргүй барааны дэлгүүр ажилладаг. Энэ дэлгүүрүүдээс гол 8 нь онгоцны буудалд ажилладаг. Улирал улирлаар бараа татан авалтыг судалдаг. Хамгийн сүүлд 2020 онд 2-р сард бараагаа татан авсан. Корона вирус гарахаас өмнө нь амжиж бараагаа авсан. Манай компани өнөөдрийн байдлаар 2 дэлгүүртэй үйл ажиллагаагаа явуулж байна. Миат олон улсын нисэх онгоц хүлээж авахаа больж дотоодын нислэг үйлддэг болсон тул МИАТ татваргүй барааны дэлгүүрүүд бүгд хаагдаж үйл ажиллагаа зогсоосон. Манайх мөн адил бараагаа татан авч дэлгүүрээ хаасан байдалтай байна.

За ингээд цааш нь үргэлжлүүлээд тайлангаа танилцуулъя.

“Жуулчин Дюти Фрий” ХК-ийн бүтэц зохион байгуулалт. Хувь нийлүүлэгчдийн хурал, ТУЗ-ын хувь нийлүүлэгчдийн хурал нь 9 гишүүнтэй, үүнээс нэр дэвшүүлэх хороо, цалин, урамшууллын хороо, аудитын хороо, мөн Гүйцэтгэх захиралтай, гүйцэтгэх захирлын харьяа Санхүү бүртгэлийн нэгж байна, нэгж нь ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогчтой. Борлуулалтын албатай, Борлуулалтын алба нь үйл ажиллагаа хариуцсан 1 менежертэй, Төмөр зам салбарын худалдааны зөвлөх 2, Албанбулаг дээр худалдааны төлөөлөгч 2, орон тооны бүтэцтэй ажиллаж байна.

Тус компанийн ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн хараат гишүүд “Таван Богд Трейд” ХХК-ийн захирал Ц.Баатарсайхан, Д.Хулан, Ц.Оргилболд, Ц.Оюунцэцэг, Ц.Цэцэнхүү, Ч.Ванчин-Эрдэнэ гэсэн 6 гишүүнтэй байна. Хараат бус гишүүд Я.Пүрэвээ, Д.Байгальмаа, В.Хүрэлхад нар, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр миний бие ажиллаж, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ байна. ТУЗ-ийн гишүүд 2020 оны 09-р сард томилогдсоноос хойш өөрчлөлт орсон зүйл байхгүй байна.

2016 оны 07-р сарын 27-ны өдрийн байдлаар "Газар Сүлжмэл" ХК-ийн нийт 65,362 ширхэг хувьцаатай байсан байна. 2016 оны 07-р сарын 28-ны өдрийн байдлаар "Газар Сүлжмэл" ХК-иас "Таван Богд Трейд" ХХК нь хяналтын багц буюу 44,251 ширхэг хувьцаа буюу 67,7 хувийг худалдан авсан байна. 2016 оны 07-р сарын 28-ны өдрийн байдлаар бусад хувьцаа эзэмшигч нар 21,111 ширхэг буюу 32,3 хувьтай байна эзлэх хувь. 2016 оны 09-р сарын 28-ны өдрийн байдлаар тендер санал гаргаж бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авснаар "Таван Богд Трейд" ХХК нь 46,355 ширхэг буюу нийт хувьцааны 70,92 хувийн эзэмшиж байна. 2022 оны 04-р сарын 06-ны өдрийн байдлаар бусад хувьцаа эзэмшигч нар 19,007 ширхэг буюу 29,08 хувийн хувьцааг эзэмшиж байна.

1-р салбар Төмөр замын дэлгүүрийн татваргүй барааны дэлгүүр нь вокзалын 5 дугаар давхарт байрладаг, гаалийн хяналтын доор үйл ажиллагаа явуулдаг.

Төмөр замдаа бол дэлгүүр нэг складтай үйл ажиллагаа явуулдаг. Оны эхнээс гаалийн байцаагч камераар хянаж байгаа учраас борлуулалт тааруу, бууралттай байна.

2-р салбар Алтанбулаг шалган нэвтрүүлэх төвийн 1-р давхарт байрладаг тэнд байрлах талбай бол 46,7 м2 талбайтай үүнээс 2 складтай. Гол орлого олдог сизон нь 6-10 сар. ОХУ гарч, орж байгаа иргэдэд үйлчилж байна.

Дээрх салбарууд нь 2020 оны 03 сарын 11-ний өдрийн Улсын онцгой комиссын тогтоолоор үйл ажиллагааг зогсоосноос хойш өнөөдрийг хүртэл ажиллаагүй хүндхэн нөхцөлд байна.

Дэлгүүрийн бараа татан авалт бол хамгийн сүүлийнх нь 2020 оны 02 сард татан авсан. Үүнээс хойш дэлхий нийтэд гарсан Короно вирус гарснаас шалтгаалаад 3 сарын 11-ний өдрөөс УОК шийдвэр гарч 6-р тогтоолоор 3 сарын 31-нийг дуустал төмөр зам нисэх бүүдлын үйл ажиллагааг зогсоосон байхад ОХУ 5 сарын 1 өдрийг хүртэл хипээрээ хүн нэвтрүүлэхгүй байх шийдвэр гаргасан. Мөн энэ хугацаанд 4 30 хүртэл агаарын зам, төмөр замын үйл ажиллагааг УОК сунган зогсоосон тул манай компанийн бүх үйл ажиллагаа зогссон байна. Ямар нэгэн орлогогүй байна. Улс орон ийм хүнд байгааг харгалзан үзэж нийт ажилтнууддаа сул зогсолт зарлан нөхөн олговор олгож байна.

За ингээд санхүүгийн тайланг болон ТУЗ-ийн дүгнэлтийг компанийн ерөнхий нягтлан бодогч Б.Алтанцэцэг танилцуулна.

Ерөнхий нягтлан бодогч Б.Алтанцэцэг:

"Жуулчин Дютри Фрий" ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн дүгнэлтийн танилцууль.

"Жуулчин Дютри Фрий" ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2017 оны зорилтуудын талаар Компанийн тухай хууль, "Жуулчин Дютри Фрий" ХК-ийн дүрмийн хүрээнд ТУЗ-ийн хурлаар хэлэлцлээ. "Жуулчин Дютри Фрий" ХК-ийн 2016 оны 07 сард тус компанийн хяналтын багцын хувьцааг худалдан авсан бөгөөд үүнээс

хойших хугацаанд тус компанийн үйл ажиллагааг амжилттай үргэлжлүүлэн ажиллуулжээ. Энэ хугацаанд гүйцэтгэх захирал, нягтлан бодогч болон үйл ажиллагааны менежер, гадаад харилцааны менежер тус бүр нэг, худалдааны төлөөлөгч 10 хүний орон тоотойгоор, зах зээлээ тэлэн ажиллагаа хийж компанийн ашигтай ажиллагааг хангаж амжилттай ажилласан байна. Компанийн засаглалыг хангах хүрээнд төлөөлөн удирдах зөвлөлийн 9 гишүүнтэй /үүнээс хараат 6 гишүүн, хараат бус 3 гишүүн бүхий/-гээр үйл ажиллагааг явуулсаар ирлээ.

Тус компани 2021 оны төлөвлөгөөгөөр 209 сая төгрөгийн борлуулалт хийх төлөвлөгөөтэй байсан үүнээс 48,3 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Корона вирусийн нөхцөл байдлаас шалтгаалан компанийн үйл ажиллагаа 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс хойш өнөөдрийг хүртэл зогссон байдалтай байгааг харгалзан нөөц бололцоогоо дайчлан ажилласан гэж дүгнэж байна.

Цаашид татваргүй барааны дэлхийн стандарт жишигт нийцсэн дэлгүүрийн үйлчилгээг нэвтрүүлэн олон улсын зорчигчид, жуулчид болон татваргүй барааны дэлгүүрээр үйлчлүүлэх эрх бүхий этгээдэд үйлчилгээг өргөн хүрээнд үзүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч ажиллахаар төлөвлөсөн байгааг тэмдэглэж байна.

Одоо хурлын дэгийн дагуу Компанийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг танилцуулна.

Ерөнхий нягтлан бодогч Б.Алтанцэцэг:

Компани 2021 оны төлөвлөгөөгөөр 209 сая төгрөгийн борлуулалт хийх төлөвлөгөөтэй байсан үүнээс 40,3 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Корона вирусийн нөхцөл байдлаас шалтгаалан компанийн үйл ажиллагаа 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс хойш өнөөдрийг хүртэл зогссон байдалтай байгааг харгалзан нөөц бололцоогоо дайчлан ажилласан гэж дүгнэж байна.

2021 оны санхүүгийн тайланг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан жагсаалтад бүртгэлтэй "Эм Жи Эм Ди Аудит" ХХК-тай гэрээ байгуулан 2017 оны 12-р сарын 31-ны байдлаар санхүүгийн тайланд Хараат бус аудиторын дүгнэлт гаргуулсан болно. Дүгнэлтэд 2021 оны 12-р сарын 31-ний санхүүгийн тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт: Дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь "Жуулчин Дюти Фрий" ХК-ийн 2021 оны 12-р сарын 31-ний санхүүгийн тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд

Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн, шударгаар илэрхийлсэн байна гэж дүгнэсэн.

Та бүхэн санхүүгийн тайлантай болон хөндлөнгийн аудитын тайлантай танилцаж болно.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Та бүхнээс өнгөрсөн оны буюу 2021 оны санхүүгийн тайлантай холбоотой асууж тодруулах зүйл байна уу.

Хувьцаа эзэмшигч А.Жавхлан: Компани нь 2021 онд хэр ашигтай ажилласан бэ? Санхүүгийн тайланд дурдсанаар ашигтай ажилласан харагдаж байна.

Ерөнхий нягтлан бодогч Б.Алтанцэцэг: Компани 2021 оны төлөвлөгөөгөөр 209 сая төгрөгийн борлуулалт хийх төлөвлөгөөтэй байсан үүнээс 48,3 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хувьцаа эзэмшигч нараас 2021 оны санхүүгийн тайлантай холбоотой асууж тодруулах зүйл байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудлаа хэлэлцье. Ерөнхий нягтлан бодогч Г.Энхгэрэл Компанийн 2022 оны санхүүгийн төлөвлөгөө, төсвийг танилцуулна.

Ерөнхий нягтлан бодогч Б.Алтанцэцэг: Энэ оны төлөвлөгөө 1,005,466,654 төгрөгийн борлуулалт хийхээр төлөвлөсөн. Нийт өртгийг 532 сая гэж төлөвлөсөн бол нийт ашиг, алдагдлыг 472 сая гэж төлөвлөсөн байна. Үүнээс Борлуулалт маркетингийн зардал 187,4 сая, ахиуц ашиг 285,1 сая, Ерөнхий удирдлагын зардал 245,4 сая төгрөг ба энэхүү зардалд ажилчдын цалин хөлс, хоол унааны хөнгөлөлт, купон, байгууллагаас төлсөн ЭМ, НДШ зардал, томилолт, бичиг хэрэг, ажилчдын сургалт, түрээсийн зардал гэх мэт багтсан байна. Үйл ажиллагааны ашиг 39,7 сая, тайлант хугацааны цэвэр ашиг 32,5 сая гэж төлөвлөсөн байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: 2021 оны санхүүгийн төлөвлөгөө, төсвөөс асууж тодруулах зүйл байна уу? Хувьцаа эзэмшигч нараас.

Байхгүй гэв.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал маань ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ын шийдвэрийг танилцуулах.

Компанийн ТУЗ нь 2022 оны 02-р сарын 16-ны өдөр хуралдаж ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-01 дугаартай тогтоол гарсан. Дээрх тогтоолоор МУ-д COVID-19 цар тахлын нөхцөл байдал үүсэж Засгийн газраас улсын хилийг хаах шийдвэр гарч, компанийн үйл ажиллагаа 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс бүрэн зогссон, 2021 оны тайлант жилийн санхүүгийн тайланг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг

хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн байна. Ногдол ашиг тараах эсэх тогтоолтой холбоотой хувьцаа эзэмшигч нараас асууж тодруулах зүйл байна уу.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: 2021 оны санхүүгийн төлөвлөгөө, төсвөөс асууж тодруулах зүйл байна уу? хувьцаа эзэмшигч нараас.

Байхгүй гэв.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлыг хэлэлцэж дууслаа. Хувьцаа эзэмшигч нараас компанийн үйл ажиллагаатай холбоотой болон өнөөдрийн хурлаар хэлэлцсэн асуудлаас асууж тодруулах зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: Хөшигтийн хөндийн сонгон шалгаруулалттай холбоотой шүүхийн маргаан ямар шатанд байгаа вэ?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Сонгон шалгаруулалттай холбоотой Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргасан боловч 2021 оны 11-р сард анхан шатны шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Мөн бид давж заалдах гомдлыг гаргасан боловч давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн. Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол мөн гаргасан боловч гомдлыг хүлээж авахаас дээд шүүх татгалзсан тул анхан шатны шүүхийн шийдвэр хэвээр үлдэж манай маргаан эцэслэн шийдвэрлээд байна. Энэ нь манай компани Хөшигтийн хөндийн нисэх буудлын сонгон шалгаруулалтад сонгогдоогүй хэвээр үлдэж байна.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: Хөшигтийн хөндийн сонгон шалгаруулалт дахин зарлагдах боломжтой юу?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Сонгон шалгаруулалт дахин зарлагдсан тохиолдолд бид мөн адил шаардлагатай материалыг бүрдүүлэн дахин сонгон шалгаруулалтад өрсөлдөөд явна. Өнөөдрийн байдлаар шинэ нисэх дээр 2 дэлгүүр ажиллаж байна. Хоёулаа сонгон шалгаруулалтад тэнцэж үйл ажиллагаа явуулж байгаа газрууд. Нэг газар нь манай шүүхийн маргаан гуравдагч этгээдээр оролцож байсан "Алтан жолоо Трейд" ХХК шалгарсан. Шинэ нисэх бүрэн гүйцэт үйл ажиллагаагаа явуулаад эхэлбэл дахиад татваргүй барааны дэлгүүр ажиллуулах сонгон шалгаруулалт зарлагдахыг үгүйсгэхгүй.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: Алтан жолоо Трейд ХХК чинь Сансар супермаркет дэлгүүрийн компани мөн үү.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Тийм ээ мөн. Энэ компани мөн татваргүй барааны дэлгүүр ажиллуулдаг.

Хувьцаа эзэмшигч С.Пүрэвжав: Манай компаниас юугаараа илүү болоод шалгарчхав? Мэдээлэл байна уу?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Шинэ нисэхийн менежментийн үйл ажиллагааг Японы тал бүхэлд нь хариуцан ажилладаг. Сонгон шалгаруулалтын урилгад заасны дагуу хэрхэн шалгаруулсан, яагаад шалгаруулаагүй, шалгаруулалтын үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй гэж заасан тул шинэ нисэхийн өөрсдийн дотоод асуудал гэсэн тайлбарыг шүүхийн шатанд өгч байсан. Мөн шүүх энэхүү тайлбарыг үгүйсгээгүй бөгөөд сонгон шалгаруулалт нь хууль зөрчөөгүй байна гэж үзсэн.

Хувьцаа эзэмшигч Б.Ганболд: 2022 онд Алтанбулаг салбар болон Төмөр зам салбар нээгдэх боломж байна уу? Дэлгүүрээ нээн ажиллуулах талаар компани хэрхэн ажиллаж байна вэ?

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр: Алтанбулаг салбар дэлгүүрийн тухайд. МУ-ын засгийн газраас тогтоол гарч ОХУ-д зорчих хөдөлгөөнийг нээхээр болсон. Хилийн гарах хөдөлгөөн нээхээр болсонтой холбоотой татваргүй барааны дэлгүүрийг нээж ажиллуулах хүсэлтийг бид Гаалийн Ерөнхий газарт гаргасан. Мөн Алтанбулаг хилийн боомт нээхтэй холбоотой ажилтнуудыг Сэлэнгэ аймаг руу томилолтоор явуулан холбогдох зөвшөөрлийг Сэлэнгэ аймгийн гаалийн газраас авсан. Хил нээгдэхтэй давхардан Алтанбулаг боомт хилийн гарах орох хэсгийн барилгыг нураан шинээр барилга барих болсон тул татваргүй барааны дэлгүүрийн гадаа талбайд ажиллуулах зөвшөөрлийг өгсөн. Иймд бид барилга шинээр баригдах хүртэлх хугацаанд гадаа талбайд зөөврийн дэлгүүр ажиллуулахаар Мастер кемп ХХК-д зөөврийн дэлгүүр бариулах гэрээг байгуулан ажиллаж байна. Хилийн гарах хэсэг одоогоор ажиллаж эхэлсэн. Газар тэгшлэх асуудлаас болоод хилийн шалган, гааль гээд төрийн байгууллагууд газраа сонгосны дараа манай дэлгүүр заасан байрлалд дэлгүүрээ байршуулахаар төлөвлөн ажиллаж байна. Төмөр зам дэлгүүрийн тухайд. Төмөр замын удирдах газарт хандаж ОХУ-руу төмөр замын хүн тээврийн вагон эхлэх тохиолдолд манай төмөр зам салбар ажиллах бололцоо бүрдэнэ. Үүний дагуу мөн гаалийн ерөнхий газарт хүсэлтээ гаргаад ажиллаж байна. Манай хамгийн том буюу борлуулалтын орлогын 60 орчим хувийг дангаар бүрдүүлдэг төмөр зам салбарыг бид аль болох хурдан нээхийг эрмэлзэн шаардлагатай зөвшөөрөл, хүсэлтийг холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Хурлын дэгийн дагуу хэлэлцсэн асуудлын хүрээнд 2 асуудлаар санал хураалт явуулна. 1-р санал хураалт ТУЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг батлах тухай санал хураалт, 2-р санал хураалт нь Компанийн 2022 оны санхүүгийн төлөвлөгөө төсвийг батлах санал хураалт явагдана.

Саналын хуудас болон санал хураалттай холбоотой асууж тодруулах зүйл байвал нээлттэй шүү.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ: Тооллогын комиссоос 2 саналын дүнгээ нэгтгэн та бүхэнд танилцуулахад бэлэн болсон байна.

Тооллогын комиссын гишүүн Ж.Түвшинтуул: Нийт өнөөдрийн хуралд 10 хувьцаа эзэмшигч оролцсоноос 100 хувийн саналаар ТУЗ-ийн 2021 санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг батлахаар шийдвэрлэсэн байна. Саналын 2-р хуудас буюу компанийн 2022 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг батлах саналын хуудсыг 100% зөвшөөрч батлахаар шийдвэрлэсэн байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ:

1. 2022 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг батлах
2. ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай тогтоолын төслүүдийг батлахаар 100 хувийн санал өгсний танилцуулав.

Хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд оруулсан 2 асуудлаар хэлэлцсэн асуудлыг 100 хувь дэмжигдсэн учраас тогтоолын төслийг батлахаар шийдвэрлэсэн тул тогтоолыг төслийг танилцуулан баталлаа.

Ингээд өнөөдрийн хурал өндөрлөж байна хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хурлыг хааж үг хэлнэ үү хэмээн Ц.Отгонбаяр захирлыг урьж байна.

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр: “Жуулчин Дютри Фрий” ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийнхээ ээлжит хуралд хүрэлцэн ирж оролцсон та бүхэнд баярлалаа. Онцгой нөхцөл байдлаас шалтгаалан бидний шууд хийгддэг байсан ажил маань хийх боломжгүй хязгаарлагдмал байна. Тийм учраас ийм хүнд нөхцөл байдалтай байгаа ч компанийн зүгээс хууль дүрэм журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийе, тайлангаа танилцуулъя гэж зориг та бүхний оролцоотой амжилттай хурлаа хийж дуусаж байна.

Ингээд та бүхний ажилд амжилт хүсэн энэ хориг маань хурдан нээгдээсэй гэж ороол дэвшүүлье ээ.

Хурлын дарга:



О.Доржханд

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Б.Бат-Эрдэнэ

2022 оны 04 сарын 27-ны өдрийн 11 цаг 10 минутад дуусав.